# Тусламж, үйлчилгээний чанарын дотоод хяналтын төлөвлөгөөний тайлан



**Хавсралт 6.**

## Тусламж, үйлчилгээний чанарын дотоод хяналтын төлөвлөгөөний тайлан

Чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний Чанар аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах
Чанар эрсдэлийн багийн үйл ажиллагаа 2023.01.15-нд бүх алба тасгийн Чанар эрсдэлийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажилласан. Багийн үйл ажиллагааны төлөвлөлтөд чиглэл өгч СҮАЗ-д үнэлгээ хийх, дотоодын хяналт үнэлгээ хийх, ОУ-ын ISO 9001:2015 стандартын тасралтгүй байдлыг хангаж ажиллахад анхаарч тусгасан.

**Чанарын зорилтууд 2023-2025 он**

2023 оны 05 сарын 29 өдрийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 2023-2025 оны Чанарын зорилтуудыг баталсан.

1. Хавдрын оношилгооны лабораторийн үйл ажиллагааг олон улсын MNS ISO 15189:2015 стандартад нийцүүлж, итгэмжлүүлэх
2. Төвийг магадлан итгэмжлэлийн баталгаажуулалтанд хамруулах
3. Хавдрын мэс заслын болон мэс заслын бус эмчилгээнд нөхөн сэргээх, эрхтэн хадгалах хөнөөл багатай эмчилгээг нэвтрүүлэх
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын зонхилон тохиолдох үүсгэгч эмэнд тэсвэртэй бичил биетэний тандалтын тогтолцоог цахимжуулж, мэдээллийн урсгалыг тодорхойлох

**Чанарын зорилтууд 2023-2025 он /Шалгуур үзүүлэлт/**

1. Хавдрын оношилгооны лабораторийн үйл ажиллагааг олон улсын MNS ISO15189:2015 стандартад нийцүүлж, итгэмжлүүлсэн байна.
2. Төвийг магадлан итгэмжлэлийн баталгаажуулалтанд хамруулж 3-4 жилээр сунгасан байна.
3. Хавдрын мэс заслын болон мэс заслын бус эмчилгээнд нөхөн сэргээх, эрхтэн хадгалах хөнөөл багатай эмчилгээг нэвтрүүлэх /дархлаа эмчилгээ, minimal invasive surgery гэх мэт/
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын зонхилон тохиолдох үүсгэгч эмэнд тэсвэртэй бичил биетэний тандалтын тогтолцоог цахимжуулж, мэдээллийн урсгалыг тодорхойлох /1.Мэдээллийн урсгалыг гаргах 2.Цахим мэдээллийн санд оруулах 3.Тасаг нэгжийн оролцоог нэмэгдүүлэх
5. Шуурхай хариу арга хэмжээг авах 5.Судалгаа, тандалтыг тогтомжуулах/

ЭМТҮЧАБА-ны төлөвлөгөөний дагуу хамтарсан болон багаар 21 тасаг, албад нийт 80 гаруй удаагийн дотоод хяналт, тойрон үзлэг хийсэн.
Нийт 60 гаруй зөрчлийг илрүүлэн нийтлэг гарсан зөрчлийг арилгуулахаар арга хэмжээнүүдийг авч, хугацаат байдлаар үүрэг даалгавар өгөн, дахин хяналт хийж үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж ажилласан.

**Тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайруулах зорилгоор:**

Шинээр болон шинэчлэн боловсруулсан 15 журам, тушаалыг холбогдох хороод болон захирлын зөвлөлд танилцуулж батлуулсан. Үүнд:

1. 2023 оны Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитын хөтөлбөр /Ерөнхий захирлын 2023 оны 01 сарын 10-ны А/02 дугаар тушаал/
2. "Орон тооны бус багийг шинэчлэн байгуулах тухай" /Ерөнхий захирлын 2023 оны 01 сарын 10-ны А/01 дугаар тушаал/
3. "Эмнэлгийн тусламж үйлчилгээний халдвараас сэргийлэх арга хэмжээг сайжруулах жил болгон зарлах тухай" /Ерөнхий захирлын 2023 оны 02 сарын 16-ны А/11 дүгээр тушаал/
4. Эмнэлгийн аюултай хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх, устгах зааврыг батлуулах /Ерөнхий захирлын 2023 оны 02 сарын 16-ны А/ дүгээр тушаал/
5. "Чанарын бодлого, зорилт, чанарын менежментийн зураглалыг батлах тухай" /Ерөнхий захирлын 2023 оны 05 сарын 29-ны А/44 дүгээр тушаал
6. "ХСҮТ-ийн Эмнэлзүйн чанарын нийтлэг болон тасаг албаны өвөрмөц шалгуур үзүүлэлт, үнэлэх журам" /Ерөнхий захирлын 2023 оны 10 сарын 03-ны А/63 дүгээр тушаал
7. Өндөр эрсдэлт эмийг хэрэглэх, хянах журам /Ерөнхий захирлын 2021 оны 10 сарын 03-ны А/18 дүгээр тушаал/ /2021.07.01
8. Эмийн эмчилгээний алдааг бүртгэх журам /Ерөнхий захирлын 2021 оны 10 сарын 03-ны А/18 дүгээр тушаал/ /2021.07.01/
9. Аман заавар өгөх журам /Ерөнхий захирлын 2023 оны 11 сарын 28-ны А/83 дүгээр тушаал/ /2023.11.28/
10. Хэвтэн эмчлүүлэгчдийн эрт үеийн анхааруулах үнэлгээний журам /Ерөнхий захирлын 2023 оны 11 сарын 23-ны А/78 дүгээр тушаал/ /2023.11.23/
11. Үйлчлүүлэгчийн унах эрсдэлийг үнэлэх журам /Ерөнхий захирлын 2023 оны 11 сарын 23-ны А/79 дүгээр тушаал/ /2023.11.23/
12. Радиологийн шинжилгээний аюултай хариу мэдээлэх журам /Ерөнхий захирлын 2023 оны 11 сарын 23-ны А/79 дүгээр тушаал/ /2023.11.23/
13. Эмнэлзүйн журам Ерөнхий захирлын 2023 оны 11 сарын 23-ны А/79 дүгээр тушаал/ /2023.11.23/
14. Жижүүр эмчийн журам /Ерөнхий захирлын 2023 оны 11 сарын 23-ны А/79 дүгээр тушаал/ /2023.11.23/
15. Аюултай хариу мэдээлэх журам Ерөнхий захирлын 2023 оны 11 сарын 27-ны А/ дүгээр тушаал/ /2023.11.23/

**Эмнэлгийн тусламж үйлчилгээний нийтлэг чанарын шалгуур үзүүлэлт**
/2023 оны 03 улирлын байдлаар/

1. Орны фонд ашиглалтын хувь – **75.7%**
2. Дундаж ор хоног – **4.2**
3. Эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь /8-24 цаг/ - **21.2%**
4. Задлан шинжилгээний хувь – **7.4%**
5. Үндсэн оношийн зөрүүний хувь - **85.7%**
6. Эрчимт эмчилгээний орны фонд ашиглалтын хувь - **75.9%**
7. Давтан хагалгааны хувь **-10,7%**
8. Мэс заслын дараах хүндрэлийн хувь - **4.14%**
9. Давтан хэвтэлтийн хувь - **3.1%**
10. Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагдагсдын тоо - **120**
11. Тухайн мэргэжлийн чиглэлээр хийж буй:
    - Судалгаа, эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлангийн тоо
    - Дотоод-**60**, Гадаад-**3**
    - Хэвлэгдсэн сэтгүүл болон хэвлэлийн тоо – **1** сэтгүүл, **300** өгүүлэл
    - Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо – Мастер-**19**, Доктор-**1**
12. Сэлгэн ажиллуулсан эмч, сувилагчийн тоо /хөдөө орон нутаг болон эмнэлэг хооронд/ - **1** эмч
13. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдсан хувь – **439** ажилтан, **92%** хамрагдсан
14. Нэг өвчтөнд ногдох эмийн зардал – **2,189,221 T**
15. Тухайн жилд тасралтгүй сургалтын кредитийн шаардлага хангасан Эмчийн хувь – **100% хамрагдсан**
16. Тухайн жилд тасралтгүй сургалтын кредитийн шаардлага хангасан сувилагчйн хувь - **100% хамрагдсан**
17. Тухайн жилд тасралтгүй сургалтын кредитийн шаардлага хангасан Эх баригчийн хувь – **0%**
18. Байгууллагын өрийн хэмжээ – **7,312,424 T**
19. Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний шинэ технологи - **11**
20. Өвчний түүх бичих зааврын мөрдөлтийн хувь -
21. Оношилгоо, эмчилгээний стандарт, зааврын мөрдөлтийн хувь -
22. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдлын тоо- **110** шийдвэрлэлтийн хувь – **100%**
23. Эмнэлгийн орчинд үйлчүүлэгч гэмтсэн тохиолдлын тоо - **9**

24. Үйлчлүүлэгчийг танин тодруулахтай холбоотой тохиолдлын тоо - **2**
25. Үйлчлүүлэгчийн зерэг сэтгэл ханамжийн хувь - **82,3%**
26. Хорт хавдар анх оношлогдож эмчлэгдсэнээс хойш 5-с дээш жил амьдарсан хүний эзлэх хувь /Үндэсний хэмжээнд/ - **43%**
27. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин /10 000 хүн амд/ - **13,6%**
28. Улсын хэмжээнд анх оношлогдсон хорт хавдартай өвтчний дотор I,II үедээ оношлогдсон хувь –**I үед 6,3%, II үед 22,5%**
29. Төвийн хэмжээнд анх оношлогдсон хорт хавдартай өвтчний дотор I,II үедээ оношлогдсон хувь – 0%
30. Хими эмчилгээний хүлээгдлийн дундаж хугацаа – **21 хоног**
31. Туяа эмчилгээний хүлээгдлийн дундаж хугацаа - **19,5 хоног**

**Зохион байгуулсан сургалт:**

2023 онд нийт 7 сэдвээр 17 удаагийн дадлагажуулсан болон бусад хэлбэрийн сургалтыг давхардсан тоогоор 827 орчим эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудад зохион байгууллсан.

Хүснэгт.1

| № | Сургалт, семинарын нэр | Удаа | Оролцсон эмч мэргэжилтний тоо |
|---|---|---|---|
| 1 | Эрсдэлийн менежментийн тогтолцоо | 17 | 146 |
| 2 | Эрсдэлийн үнэлгээ хийх | 17 | 146 |
| 3 | Тохиолдол бүртгэх мэдээлэх тухай | 17 | 146 |
| 4 | Цахим өвчний түүх бичих хадгалах, хэвлэх журам | 2 | 50 |
| 5 | Эрт үеийн анхааруулах үнэлгээ | 9 | 103 |
| 6<br>7 | Байгууллагын соёл<br>Эрүүл мэндийн салбарт яагаад ISO хэрэгтэй вэ? | 9 | 103 |

1. Дотоод аудиторын сургалт: Ерөнхий захирлын А/52 тоот тушаалаар дотоод аудитор бэлтгэх 3 хоногийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтад 30 гаруй хүн хамрагдсан. Дадлага сургалтаар дотоод аудитын хөтөлбөрийн дагуу 4 багийн аудиторууд 34 тасгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн.
2. Тэргүүлэх аудиторын сургалт: Тэргүүлэх аудитор бэлтгэх 14 хоногийн сургалтанд дотоод аудитороор бэлтгэгдсэн 1 ажилтан суралцаж тэргүүлэх аудитор болсон.
3. Чанар-эрсдэлийн багийн гишүүд, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт чанарын сургалт зохион байгуулах
4. ХСҮТ болон G2G сургалтын төвтэй хамтран ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо шаардлага стандартын сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

5. “Тэргүүлэх аудит” - 1 удаа
6. “Дотоод аудит” - 1 удаа
7. Одоогийн байдлаар 30 гаруй дотоод аудиторыг бэлтгээд байна.
8. Чанар, аюулгүй байдал эрсдэлийн удирдлагын хорооны хурал

ЭМТҮЧАБА-нд 2022 оны байдлаар нийт 16 тохиолдол бүртгэгдсэнээс олон дахин давтагдаж байгаа цусны нэгжид бүртгэгдсэн тохиолдол болон ХМНТ-н Цус зохицуулах нэгжид бүртгэгдсэн тохиолдлуудыг хэлэлцэх, Дурангийн тасгийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйл дээр Чанар аюулгүй байдал эрсдэлийн хорооны хурлыг 2 удаа зохион байгуулсан.

Чанар аюулгүй байдал эрсдэлийн хорооны хурал

1. 2022.03.16 ны өдөр ХМНТ-н Цус зохицуулах нэгжид бүртгэгдсэн тохиолдлуудыг хэлэлцэх зорилгоор хуралдсан. <u>Хурлын шийдвэр:</u>

    1. Цусны нэгжийн СҮАЗ боловсруулах, холбогдох хүмүүст танилцуулах, батлуулах
    2. Эрсдэлийн сургалт зохион байгуулах
    3. Тохиолдол мэдээлэх журмын дагуу сургалт зохион байгуулах
    4. Цус хадгалах цэгийг лабораторын тасаг руу шилжүүлэх
    5. Сувилахуйн алба болон Цус сэлбэлтийг зохицуулах хорооны хурлаар гарсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан авах
    6. Цусны эмч болон сувилагчийн үйл ажиллагааг өөрсдийн санал дээр үндэслэн цаашид үргэлжлүүлэн ажиллах шийдвэр гарсан бөгөөд үүний дагуу дараах ажлуудыг зохион байгуулсан.

2. 2022.11.09 ны өдөр Дурангийн тасаг “Эмнэлгийн тусламж үйлчилгээ, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлүүд” /унтуулгатай ажилбар, ариутгал халдваргүйжтгэл, тоног төхөөрөмж, хүний нөөц, хүчилтөрөгч, их засвар г.м/ <u>Хурлын шийдвэр:</u>

    1. Ариутгалын хэсгийн урсгал зөв болгох
    2. 3 дамжлагат урсгалыг хэрэгжүүлэх
    3. Төвийн шугамд холбох
    4. Лабораторын тасаг Грам(-) Грам (+) нарийвчлал өгөх
    5. Шинжилгээний китүүд байгаа эсэх
    6. Хүчилтөрөгчийн хоолой татуулах
    7. АШУҮИС -ийн Биоанагаахын багш нараас сургалт авах
    8. Стандартын дагуу ариутгал халдваргүйтгэлийн бодис нийлүүлэх
    9. Халдваргүйтгэлийн асуудлыг ХХСА-нд шилжүүлэх.

**Эмнэлзүйн удирдамж, зааврын хэрэгжилт**

Хавдар судлалын үндэсний төв нь үндэсний хэмжээнд хавдрын тусламж үйлчилгээг үзүүлэхдээ 467 стандарт, удирдамж зааврыг мөрдөн ажиллаж байна. 2022 оны тусламж үйлчилгээний стандарт удирдамж зааврын хэрэгжилтийн хувь 94,2% байна.

**Эмнэлзүйн хорооны хурал**

2023 онд Эмнэлзүйн хорооны хурлаар 46 удирдамж, заавар батласан.

Хүснэгт.2

| Тасаг | ЭЗХХ-д оруулсан удирдамж, үйлдлийн стандарт | Батласан | Буцаагдсан |
|---|---|---|---|
| ТХМЗТ | Мэдрэлийн хавдрын мэс заслын үйлдлийн удирдамж | 32 | 0 |
| | Толгой хүзүүний байрлалын хавдрын үйлдлийн удирдамж | 3 | 0 |
| Ангиографи | TACE ажилбарын үйлдлийн удирдамж | 1 | 0 |
| ЕМЗТ | Бөөрний хавдрын мэс заслын үйлдлийн удирдамж | 6 | 0 |
| ЭЦНБМЗТ | Өндөр хяналтад нэгжийн журам | 1 | 0 |
| Хөхний төв | Хөхний хавдрын оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар | 0 | 1 |
| Сэргээн засах тасаг | Эрчимт эмчилгээ ба мэс заслын дараах тасагт хөдөлгөөнд эрт оруулах удирдамж | 0 | 1 |
| Туяа эмчилгээний тасаг | 3 Хэмжээст конформал туяа эмчилгээний заавар<br>IMRT/VMAT эмчилгээний эмнэлзүйн заавар<br>Дотуур туяа эмчилгээний эмнэлзүйн заавар | 3 | 0 |

**Бүх тасгийн яаралтай тусламжийн эмийн шүүгээний бэлэн байдал, хорт болон сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээнд хяналт тавих**

ЭМТҮЧАБА-ны дотоод хяналтын хуваарийн дагуу жилд 16 тасаг нэгжийн яаралтай эмийн шүүгээний бэлэн байдал, яаралтай тэргэнцрийн бэлэн байдалд хяналт хийсэн. Хяналтын үед гарсан зарим зөрчлүүдийг залруулах арга хэмжээг тжхай бүрт авч хэрэгжүүлсэн бол Ангиографийн тасгийн эмийн шүүгээний 5S алдагдсан тул тасгийн ахлах сувилагчид хугацаат үүрэг даалгавар, ЯТТ-т мансууруулах сэтгэл нөлөөт эмтэй холбоотой зөрчил гарсан тул тасгийн ахлах сувилагчид "Шаардах хуудас"-аар хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хянаж ажилласан. Хамгийн элбэг тохиолддог зөрчилд эмийн хугацааны самбарыг ашиглаж, хадгалах хугацаа дөхсөн эмийг 3 сарын өмнө эм зүйч, ахлах сувилагч нарт мэдээлж байх, эм тарианы орлогын захиалга хийх, хугацаат эмийн самбарын тэмдэглэл хөтлөх.

**Аюулгүй байдлын тойрон үзлэгийг тогтмолжуулах**

Төвийн аюулгүй байдлын эргэлтийг албаны дарга Б.Баасанжав захирлын зөвлөлийн хамт хийхээс гадна амбулаторийн үйл ажиллагаанд хийх хяналтыг ЭМТҮЧАБА-ны дарга долоо хоног бүрийн даваа гарагт, чанарын менежер мягмар гарагт, эрсдэлийн менежер лхагва гарагт тогтмол хяналт хийж байна. Тасгууд болон талбайн тойролтыг долоо хоногт 1-3 удаагийн тойрон үзлэг- обходыг тогтмол хийж тусламж үйлчилгээнд хяналт тавьж ажиллаж шаардлагатай тохиолдолд захирлын зөвлөлд танилцуулга хийсэн. Тухайлбал: Хүнд өвчтөний мэдээлэл, 14-өөс дээш олон хоногоор хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний талаарх мэдээлэл, хүндрэлийн мэдээлэл гм. Гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг тухай бүр авч ажилласан.

Стандарт үйл ажиллагааны зааварчилгаа болон журмын хэлэлцүүлэг, сайжруулалт хийх

Дотоод аудитын хөтөлбөрийн дагуу 2022 оны 2 сард захиргааны 9 албаны үйл ажиллагаанд, 5 сард 8 тасгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх үед тасаг албаны СҮАЗ-нд үнэлгээ хийж шинэчлэх шаардлага байгааг тодорхойлсон. 2022 оны 4-р улиралд Мэдрэлийн мэс засал, Урологийн мэс засал, Халдвар хяналт сэргийлэлт, Даатгал статистикийн албаны СҮАЗ шинэчлэх шатандаа явна.

ЭМС-ийн 2019 оны А/566 тоот тушаалын 2-р хавсралт "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах заавар", Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2021 оны А/16 тушаалаар батлагдсан "Эрсдэлийн удирдлагын журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор ЭМТҮЧАБА-ны Эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежер Б.Мандхай 2022.04.11-2022.05.17-ны хооронд нийт 34 алба, тасгийн 233 ажилтанд "Эрсдэлийн менежментийн тогтолцоо" сэдвээр сургалт орсон.
Сургалтын дараа тасаг, албадуудаас эрсдэлийн төлөвлөгөөний загвар (хавсралт 3) – ын дагуу Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөгөөг авсан. 2022.10 сарын 30-ны байдлаар 34 тасаг, албаны Эрсдэлийн төлөвлөгөө ирсэн. Тасаг албадаас ирсэн эрсдэлийн төлөвлөгөөг Эрсдэлийн менежер хянах, эрсдэлийн үнэлгээ, төлөвлөгөөг нэгтгэх ажлыг хийж төвийн эрсдэлийг үнэлгээ, түүнийг даван туулах төлөвлөгөөг боловсруулан гаргасан.

Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор хийгдэж буй дотоодын хяналт үнэлгээний үед холбогдох дүрэм журам стандарт зөрчсөн тохиолдлуудыг бүртгэж ЭМТҮЧАБА-аас "Анхааруулах хуудас, Шаардах хуудас"-аар хугацаат үүрэг даалгавар өгсөн.
Анхааруулах хуудас-7 /Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн ахлах сувилагч Г.Уранцэцэг, Сувилахуйн албаны дарга Ю.Оюунзул, Хими эмчилгээний тасгийн их эмч С.Удвал, Цээжний хөндийн мэс заслын тасгийн эрхлэгч Б.Ганзориг, Сувилахуйн алба, ЭЦНБМЗТ сувилахуйн баг, ХМНТ-ийн эмч Чинбат/
Шаардах хуудас-5 /Ерөнхий мэс заслын тасгийн их эмч Э.Эрхэмбаяр, Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч Ц.Пүрэвдулам, Байгууллагын менежмент аюулгүй байдлын албаны ажилтан Г.Эрдэнэцэцэг, Ерөнхий мэс заслын тасгийн их эмч Ч.Бат-Оргил/, ЭЦНБМЗТ Г.Үнэнбат нарт өгч гарсан зөрчлийг арилгах, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх талаар шаардах хуудас хүргүүлсэн.

**Дотоод аудит хөтөлбөр**
2023 оны ерөнхий захирлын А/68/ дугаар тушаалаар батлагдсан Дотоод аудитын хөтөлбөрийн дагуу Нэгдүгээр баг 2023 оны 2 сард 9 тасаг алба, Хоёрдугаар баг 2023 оны 5 сард 9 тасаг алба, Гуравдугаар баг 2023 оны 8 сард 8 тасагт, Дөрөвдүгээр баг 10 сард 8 албаны үйл ажиллагаанд дотоод аудит хийж аудитын үр дүнг захирлын зөвлөлд танилцуулсан тасгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна.
**1-р баг нь** 9 албаны үйл ажиллагаанд дотоод аудит хийснээс:

- **Шаардлага хангасан-7** /Ангиографийн тасаг, Амбулаторийн тасаг, Эмнэлгийн хоол, шим тэжээлийн тасаг, Сэргээн засах тасаг, Эмнэлзүйн эмгэг судлалын тасаг, Үйлчлүүлэгчийг дэмжих алба, Дүрс оношилгооны тасаг/
- **Үл тохирол илэрсэн-2** /Дурангийн тасаг, Эмгэг судлалын тасаг/

**2-р баг нь** 9 тасаг, албаны үйл ажиллагаанд дотоод аудит хийснээс:

-**Шаардлага хангасан-7** /Халдвар хяналт сэргийлэлтийн алба, Эмзүйн алба, Эрчимт эмчилгээний тасаг, Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг, Сувилахуйн алба, Туяа эмчилгээний тасаг, Элэг шилжүүлэн суулгах алба/

-**Үл тохирол илэрсэн-2** /Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба, Хөнгөвчлөх эмчилгээний тасаг/

**3-р баг нь** 8 тасгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийснээс:

- **Шаардлага хангасан-8** /Элэг цөс нойр булчирхайн мэс заслын тасаг, Толгой хүзүү паластик нөхөн сэргээх мэс заслын тасаг, Хими эмчилгээний тасаг, Цээжний хөндийн мэс заслын тасаг, Ерөнхий мэс заслын тасаг, Яаралтай тусламжийн тасаг, Хөхний төв, Хагалгаа мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасаг/
- **Үл тохирол илэрсэн-** 0

**4-р баг нь** 8 тасаг албаны үйл ажиллагаанд дотоод аудит хийснээс:

- **Шаардлага хангасан-7** /Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ сургалтын алба, Хорт хавдар тандалт эрт илрүүлгийн алба, Хүүний нөөц хөгжлийн алба, Санхүү эдийн засгийн алба, Мэдээлэл технологийн алба, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын алба, Хүний нөөц хөгжлийн алба/

**Үл тохирол илэрсэн-1** /Байгууллагын менежмент аюулгүй байдлын алба/

**Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн**

- 2023 оны 10 сарын байдлаар нийт 100% (n=5180) хагалгаа хийснээс 2.2% (n=117) мэс заслын дараах шархны халдвар илэрсэн.
- 2023 оны 10 сарын байдлаар нийт 11029 төвийн венийн гуурс тавьснаас илэрсэн халдвар 0.05% (n=6)
- Бусад гуурс нийт 22348 гуурс тавьснаас 0.09% халдвар илэрсэн. (n=21) /цээж, хэвлий гуурс зэрэг/
- 2023 оны 10 сарын байдлаар 827 шээсний катетр тавьснаас илэрсэн халдвар 2.6% (n=22)
- 2023 оны 10 сарын байдлаар 252 зохиомол амьсгалын аппарат тавьснаас илэрсэн халдвар илрээгүй.
- 2023 оны байдлаар нийт эмч ажилтанаас 39, өвчтөнөөс 7 коронавируст халдварын тохиолдол бүртгэгдсэн.
- Өвчтөн, сахиураас нийт 4243 сорьц авсанаас 71 халдвар илэрсэн. Эмч ажилтан нийт 256 сорьц авсанаас 40 халдвар илэрсэн.
- Хэвтэн эмчлүүлэгчээс 7 сорьцыг тээвэрлэж, халдвар илэрсэнээр, 1 өвчтөнийг тухайн тасагт тусгаарлан эмчилсэн. Нийт 46 тандалтыг хийсэн.
- Томуугийн харуулдан тандалтын арга хэмжээг зохион байгуулж, нийт 2 удаа сорьц илгээсэн. Сорьцоор В хүрээний томуугийн вирус илэрсэн. Тандалтын мэдээний тайланг 7 хоног бүр ХӨСҮТ-рүү хүргүүлж ажиллаж байна.
- 2023 оны 10 сарын байдлаар нийт 9 тохиолдол бүртгэгдэж, хариу арга хэмжээг зохион байгуулсан. /коронавируст халдвар-2, Staphylococcus pseudintermedius зоонозын халдвар-1, Сүрьеэгийн тохиолдол-2, Салхинцэцэг-1, ДОХ тохиолдол-2, тэмбүү-1 зэрэг болно./

Эмнэлгийн хэмжээнд яаралтай тусламжийн тасагт 1, ТХМЗ-ын тасагт 1, ЕМЗТ-т 1 тусгаарлах өрөөг зохион байгуулж ажиллаж байна. Бэлэн байдал хангасан байдалд үнэлгээг хийхэд:

ТХМЗТ 76.6%, ЕМЗТ 80%, ЯТТ-т 86.6% тус тус үнэлэгдэж, зөрчлийг арилгаж ажиллаж байна. Цаашид тасаг бүрт тусгаарлах өрөөг зохион байгуулж ажиллана.
Бэлэн байдал хангасан байдалд үнэлгээг хийхэд:
ТХМЗТ 76.6%, ЕМЗТ 80%, ЯТТ-т 86.6% тус тус үнэлэгдсэн.

**“Нээлттэй хаалга”–ны өдөрлөг**

2023 онд “Таны гарт-Таны эрүүл мэнд” уриан дор нээлтэй хаалганы өдөрлөгийг төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд нийт 18 тасаг, алба хийсэн. Өдөрлөгийн үеэр тасаг албаны үйл ажиллагааг таниулан сурталчлах, үйлчлүүлэгч болон ард иргэдэд тусламж, үйлчилгээний талаарх мэдлэг мэдээлэл өгөх, ЭМБ олгох сурталчилгааны материал 195 ш тарааж хамрагдсан хүн бүрт эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл өгөх зэрэг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхээс гадна эмчийн үзлэг, зөвлөгөө 165 хүнд, хоол зүйчийн зөвлөгөө, хөдөлгөөн засалчийн зөвлөгөө 50 хүнд, сувилагч нар сувилахуйн тусламж үйлчилгээ 321 хүнд үзүүлж, зэрэг тусламж үйлчилгээг давхардсан тоогоор нийт 700 гаруй хүнд үзүүлсэн байна.





Зураг. 1, 2, 3

Үйлчлүүлэгчдэд хорт хавдрын талаар зөвөлгөө зөвлөмж өгч, хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, талаар мэдээллийг нийт-34 хүнд өгсөн.

Таван байрлалын хавдраас урьдчилан сэргийлэх, тогтмол үзлэг шинжилгээнд хамрагдах талаар зөвлөж, хавдрын эсрэг тараах материалуудыг тараасан.

- Ходоодны хавдраас сэргийлье
- Элэг цөс нойр булчирхайн хорт хавдраас сэргийлье
- Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлье
- Хөхний хорт хавдраас урьдчилан сэргийлье
- Хими эмчилгээ гэж юу вэ?
- Шулуун гэдэсний хорт хавдраас сэргийлэх

Мөн хими, туяа эмчилгээ, мэс заслын дараах анхаарах зүйл, асаргаа сувилгаа, хооллолтын талаар зөвөлгөө, зөвлөмжийг нийт-28 эмчлүүлэгч болон гэр бүлийн гишүүдэд өгсөн.

Мөн ҮДА-ны Нийгмийн ажилтан, Хоол зүйч нар нийгмийн дэмжлэг, хэрэгцээний талаар болон хоол зүйч хооллолтын талаар зөвөлгөө өгч ажилласан. Нийт-24 үйлчлүүлэгчид зөвлөгөө өгсөн болно.




Зураг. 4,5

Мөн туяа эмчилгээ хийлгэх үед гарах гаж нөлөө, эмчилгээний явц, анхаарах асуудал, туяа эмчилгээний үед болон дараа халдвараас сэргийлэх арга хэмжээний талаар зөвлөмжийг өгч ажиллалаа. Хавдрын үеийн туяа эмчилгээний тухай, IMRT эмчилгээний дэвшилтэт технологи – шинэ технологийн танилцуулга, гар угаах дараалал видеог тус бүр үйл ард иргэд үйлчлүүлэгчдэд танилцуулав.





Зураг. 6,7

Эрхтэн тус бүрийн хавдрын туяа эмчилгээ, хавдраас урьдчилан сэргийлэх, туяа эмчилгээний зөвлөмж, халдвараас сэргийлэх хяналтын арга хэмжээний талаар нийт 15 төрлийн зурагт хуудас, зөвлөмж материал 220 ширхэгийг тараасан болно.

**Яаралтай тусламжийн тасаг нь** төвөөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдэд **"Нээлттэй хаалганы өдөрлөг"** зохион байгуулан, амин үзүүлэлтүүд үзэх, эрүүл мэндийн боловсрол олгох болон яаралтай тусламжийн эмч, зүрх судасны эмч, цус сэлбэлтийн эмч нарын нарийн мэргэжлийн зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаа явуулсан.

**"Амилуулах суурь тусламж"**, **"Цусны донорын тухай мэдээлэл"**, **"Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлс, түүнээс сэргийлэх аргууд"**-ын талаар

үйлчлүүлэгчдэд сургалт зохион байгуулсан. Давхардсан тоогоор нийт 138 үйлчлүүлэгч хамрагдсан.





Зураг. 8,9.

**“Чанарын өдөрлөг”**

“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал” дэлхийн өдөр-2023 холбоотойгоор тус төв нь "Үйлчлүүлэгчийн дуу хоолойг сонсоё" сэдвийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө гарган батлуулж аяныг 2023 оны 09 сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Мөн оны хувьд “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зарчим” уриатайгаар төвийн Халдварын хяналт сэргийлэлтийн албанаас зохих үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

2023 онд Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрийг зохион байгуулах удирдамжийг батлуулж, нийт 9 тэмдэглэлт өдрийг зохион байгуулахаас 2 өдөрлөгийг тэмдэглэн өнгөрүүлээд байна. Үүний нэг болох “Нээлттэй хаалга” өдөрлөгийн үйл ажиллагааг 2023.01.31-ний өдөр 10:00-12:00 цагийн хооронд эмнэлгийн цахим бүртгэлийн хэсэгт зохион байгуулав. Тус үйл ажиллагааг Халдвар хяналтын сэргийлэлтийн алба, Туяа эмчилгээний тасаг, “Тавин-Ус” ХХК хамтран зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр туяа эмчилгээ хийлгэх үед гарах гаж нөлөө, эмчилгээний явц, анхаарах асуудал, туяа эмчилгээний үед болон дараа баримтлах халдвараас сэргийлэх арга хэмжээний талаар зөвлөмжийг өгч ажиллалаа. Туяа эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж байгаа болон үйлчилгээ авч байгаа 28 үйлчлүүлэгчид мэдээллийг өгч, артерын даралт хэмжих, зүрхний цохилтын тоо тоолох, биеийн халуун хэмжих, жин үзэх зэрэг сувилахуйн тусламж үйлчилгээ, халдвараас сэргийлэх хяналтын чиглэлээрх зөвөлгөөг нийт 181 хүнд хүргэсэн. Эрхтэн тус бүрийн хавдрын туяа эмчилгээ, хавдраас урьдчилан сэргийлэх, туяа эмчилгээний зөвлөмж, халдвараас сэргийлэх хяналтын арга хэмжээний талаар нийт 15 төрлийн зурагт хуудас, зөвлөмж материал 220 ширхэгийг түгээв. Мөн 0,1%-ийн хамар, залгиур зайлах хлоргексидин 50 ширхэг болон гар халдваргүйжүүлэх салфеткийг 300 ширхэг, шарх цэвэрлэх 0.2% хлоргексидин 100 ш-ийг түгээж, гар угаах, халдваргүйжүүлэх дарааллыг зааж зөвөлгөө өглөө.

2023.05.05-ны өдөр дэлхийн гарын ариун цэврийг сахих өдрийг зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүллээ. Тус өдөрлөгийг коронавируст халдварын дэгдэлттэй холбоотойгоор цахим хэлбэрээр зохион байгуулж, гарын ариун цэврийг сахих талаар уриалсан эмч ажилтаныг хамруулсан видео контентийг хийж, байгууллагын цахим хуудсаар цацсан. Хандалт 1520, хуваалцсан 38, таалагдсан 94. Мөн сурталчилгааны, үзүүлэн самбар, тараах материал, гар угаах дарааллыг үзүүлсэн видео контент зэргийг бэлтгэж, түгээсэн.



Тус видео контентод 62 эмч ажилтан идэвхитэй оролцлоо. Тус өдөрлөгтэй холбоотойгоор байгууллагын гар угаах, халдваргүйжүүлэх зааврыг нэгдсэн байдлаар шинэчлэн 3, Үйлчлэгч нарын ярианд 2 удаа мэдээллийг нийт давхардсан тоогоор 788 эмч, ажилтан, удирдлагын багт тус тус мэдээлсэн

Зураг 10. **Мэс заслын дараах хүндрэл** /3 улирлын байдлаар/

Төвийн хэмжээнд 2023 оны 3-р улирлын байдлаар мэс засал нийт **4,391** удаа хийсэн байна. Мэс заслын тасагт нийт 2,731 мэс засал, Ангиографийн болон Дурангийн тасагт нийт 1660 ажилбар хийгдсэн байна. Эдгээр мэс заслын дараа гарсан хүндрэлийг идэвхтэй тандалтын аргаар илрүүлэн бүртгэж бүртгэгдсэн хүндрэлийг Клавиэн–Диндо-гийн ангилалаар судаллаа.

Энэ ангилал нь 7 түвшинтэй (I, II, IIIa, IIIb, IVa, IVb, V). Судалгааны чиглэлээс хамааран a, b гэсэн дэд бүлэгтэй бөгөөд ер нь 5 түвшинд хуваагддаг.

Тус төвийн хэмжээнд **4,391** мэс засал хийгдсэн бөгөөд мэс заслын дараах хүндрэл **183** тохиолдол ба дундаж хүндрэлийн хувь нь **4,17%** байна.

2023 оны 1-р улирлын байдлаар мэс заслын тасгуудийн дундаж ор хоногийг харьцуулж үзэхэд төвийн хэмжээнд нийт **899** дундаж **5,20** ор хоног байна. Хамгийн өндөр нь ЭЦНБМЗТ 11,4 хоног, ЦХМЗТ 9,7 хоног, ЕМЗТ 8,1 хоног байгаа бол Хамгийн цөөн ор хоногтой нь Дурангийн тасаг 2,3 хоног Ангиографийн тасаг 2,8 хоног байна.

Нийт хүндрэлийн Шархны халдвар бүхий **I** түвшиний хүндрэл **107** буюу **59,1%** нь ерөнхий унтуулга бүхий давтан мэс засал хийгдсэн хүндрэл **41** буюу **22%** бүртгэгдсэн бол Гипокси, бодисын солилцооны ацидоз, хавагналт бүхий **II** түвшний хүндрэл **3** буюу **1,6%,** байгаа бол 32 буюу **17,1%** нь нас баралт буюу **5-р** түвшний хүндрэл тохиолдсон байна.

**Нас баралтыг тасгаар нь авч үзвэл:**

Мэс заслын дараах хүндрэлээр **31** нас баралт гарсан.

2023 оны 03-р улирлын мэс заслын дараах хүндрэлийн тоо, хүндрэлийн хувийг харьцуулж үзэхэд өмнөх оны мөн улиралд **55** хүндрэлийн тоо буюу 3.4% байсан бол 2023 оны 3-р улиралд **183** хүндрэл хүндрэлийн хувь **4,17%** тай болж өссөн байна.

**Хүндрэл болон нас баралтын тасагчилсан конференцийг зохион байгуулан ажилласан**.

2023 оны 03 улирлын байдлаар ХСҮТ-ийн нийт нас баралт 283, хөнгөвчлөх эмчилгээний оноштой нас баралт 161, тасгийн нас баралт 51, яаралтай тусламжийн тасгаар 71 бүртгэгдсэн.

Тасгийн нас баралтаас эмгэг судлалын шинжилгээ-20 удаа хийгдсэн онош болон хүндрэлийн зөрүү гарсан-4, тасагчилсан-6 удаа конференцийг зохион байгуулсан байна.

ЭМТҮЧАБА-ны дотоодын хяналтын хуваарийн дагуу хэвтэн эмчлүүлсэн мэс заслын болон мэс заслын бус тасгуудын эмчилгээ хийгдсэн эмчлүүлэгчдийн цахим өвчний түүхийн бичилтэнд хяналт хийдэг.

Хяналтыг хийхдээ:

1. ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол"-ын дагуу хяналт,
2. Хавдар судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/85 тоот тушаал Цахим өвчний түүх бичих, хэвлэх, хадгалах журам
2 3.Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаал, ЭМС-н А/611 тоот тушаалуудыг үндэслэн:
3 2022 оны 12 сар, 2023 оны 1,2,3 сард хэвтсэн 11 тасгийн 55 эмчийн 103 өвчний түүхийг сонгон хяналт хийсэн. Эмч тус бүрт тайланг танилцуулж гарын үсэг зуруулан, илэрсэн зөрчлүүдийг танилцуулж, зөвлөмж өгч, цахим өвчний түүхийн бичилтийг сайжруулж ажиллахыг анхааруулсан.
4 Хагас жилийн байдлаар даатгалын хасагдал буурсаар байна. Цаашид анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Цахим өвчний түүх бичих, хэвлэх, хадгалах журмыг мөрдөж ажиллах.
2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 12 дугаар тогтоол, үндсэн болон дэлгэрэнгүй шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах.
3. Эмч нараас сувилахуйн тусламж үйлчилгээнд тавих хяналт, сувилагчийн нараас ирэх мэдээлэл дүн шинжилгээ хийх, өвчний түүхэнд тусгах /14,15,19/
4. Мэс засал эмчилгээ хийх үеийн ахнах шатны маягтуудын хөтлөлтийг сайжруулах
5. Хэвтэх үеийн зовиур, асуумжаар илрэх шинж тэмдгийг илүү тодорхой тэмдэглэх
6. Хавдрын үе шат, явцыг үнэлж TNM ангилалаар тогтоож, тэмдэглэсэн байх
7. Эмчилгээний хоолны заалтыг үзлэгийн тэмдэглэлд бичих
8. Эмчлэгч эмч үзлэг хийсэн тухай тэмдэглэлийг өдөр бүр хөтөлсөн байх.
9. Хийгдэх мэс заслын нэрийг бүтнээр нь монгол хэл дээр тодорхой, гаргацтай бичсэн байх. Төлөвлөгөөт болон яаралтай эсэхийг тусгасан байх
10. Үйлчлүүлэгчийг өрх, сум, тосгоны болон мэргэжлийн эмчийн хяналтанд гаргасан тухай тэмдэглэл бичсэн байх
11. Өвчний түүхийн клиникийн урьдчилан оношийн үндэслэл хэсэгт ялган оношлох эмгэг эсвэл хам шинжүүдийг тодорхойлсон байх.
12. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын журам-д заасан "Нэхэмжлэлийн хяналтын шалгуур"-г хангаж ажиллах.
13. Цахим өвчний түүх бичих журмын хэрэгжилтэнд Тасгийн эрхлэгч хяналт тавьж ажиллах, сайжруулах

Анхан шатны маягтын хөтлөлт, нэхэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу дотоодын хяналтыг тасгийн Чанар эрсдэлийн багаас улирал бүр хийж ЭМТҮЧАБА-д тайланг ирүүлдэг.

Дотоод хяналтыг хийхдээ: Батлагдсан хуваарийн дагуу хийдэг (Зураг 11-14).



Зураг.11,12,13,14. Дотоод хяналтын хуваарь

ХЯНАСАН: ЭМТҮЧАБА-НЫ ДАРГА Б.БААСАНЖАВ

ТАЙЛАН ГАРГАСАН: ЧАНАРЫН МЕНЕЖЕР М.БАТ-ОЧИР